



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургууль**

Сургалтын хөтөлбөрийн нэр: **“Нүүр ам судлал”**

Индекс: **D091101**

Шинжээчийн баг:

Ахлагч: Ж.Даваа

Гишүүд: Б.Оюунбат

Л.Баярцэцэг

2019-03-20-21

Агуулга

Хуудас

Товчилсон үгийн тайлбар	4
I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга.....	7
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	8
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....	8
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	13
Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	16
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	23
Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа.....	27
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	35
Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	38
Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	41
V. Оролцогчдын нэрс	44
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.....	44
II. Оюутны нэр.....	44
III. Ажил олгогч.....	45
IV. Төгсөгчид.....	45
VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	46
VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	47
VIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	48

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгуулга
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ИСНЭ	Их Сургуулийн Нэгдсэн Эмнэлэг
ИСУМС	Их Сургуулийн Удирдлага Мэдээллийн Систем
НАС	Нүүр Ам Судлал
НАСС	Нүүр Ам Судлалын Сургууль
НАЭ	Нүүр Амны Эмчилгээ
НАГЗ	Нүүр Амны Гажиг Засал
НАМЗ	Нүүр Амны Мэс Засал
НАСЗ	Нүүр Амны Согог Засал
НАСЭ	Нүүр Ам Судлалын Эмнэлэг
НАТЭА	Нүүр Амны Техник Эрүүл Ахуй
НАССОЗ	Нүүр Ам Судлалын Сургуулийн Оюутны Зөвлөл
СБЗА	Сургалтын Бодлого Зохицуулалтын Алба
СБЗГ	Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар
ТЗЭШ	Төлөвлөгдсөн Зорилготой Эмнэл зүйн Шалгалт
ТӨСА	Төгсөлтийн Өмнөх Сургалтын Алба
ИХ	Улсын Их Хурал
УКТЭ	Улсын Клиникийн Төв Эмнэлэг
ХИДСХолбоо	Хувийн Их Дээд Сургуулиудын Холбоо
ХНАСУС	Хүүхдийн Нүүр Ам Судлал Урьдчилан Сэргийлэлт
ШУТДС	Шинжлэх Ухааны Технологийн Дэмжих Сан
ШУТС	Шинжлэх Ухаан Технологийн Сан
ЭМБ	Эрүүл Мэндийн Байгууллага
ЭММЗ	Эрүүл Мэндийн Мэдээлэл Зүй
ЭМНА	Эрүүл Мэндийн Нийгмийн Ажилтан
ЭМШУИС	Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭХЭМҮТ	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Нүүр ам судлал”	
Индекс	D091101	
Шинжээчид	<p>Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: Ж.Даваа-МУИС-ийн багш, доктор, профессор</p> <p>Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: Б.Оюунбат-Этүгэн их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн захирал Л.Баярцэцэг- Апекс менежмент ХХК-ийн гүйцэтгэх захирал</p>	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Зохицуулагчийн нэр, албан тушаал: Ажлын албаны ахлах мэргэжилтэн Б. Мядагмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2019-03-12	Зохицуулагч шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгсөн.
	2019-03-18	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид өгсөн.
	2019-03-20-21	Шинжээчид сургууль дээр ажилласан.
	2019-03-20	Өөрийн үнэлгээний багийнхантай уулзалт хийсэн.
	2019-03-20	Хөтөлбөрийн материал, нотолгоотой баримтуудтай танилцсан.
	2019-03-20	Сургуультай танилцсан.
	2019-03-20	Оюутнуудтай уулзалт хийсэн
	2019-03-20	Багш нартай уулзалт хийсэн
	2019-03-20	Хөтөлбөртэй холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох ажилтануудаас тодруулсан, лавлагаа авсан.
	2019-03-21	АШУҮИС-ийн Номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцсан.
	2019-03-21	Тухайн хөтөлбөрийн багш, тэмхимийн эрхлэгч нартай ярилцлага, хийж хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн болон хичээлийн хөтөлбөрийн уялдаа холбооны талаар тодруулсан.
	2019-03-21	Ажил олгогчидтой уулзалт хийсэн.
	2019-03-21	Төгсөгчидтэй уулзалт хийсэн.
	2019-03-21	Хөтөлбөртэй холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох ажилтануудаас тодруулсан, лавлагаа авсан.

	2019-03-21	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцаж, түүний дагуу шинжээчийн багийнхан ярилцан зарим асуудлыг тодруулан санал солилцсон.
	2019-03-21	Шинжээчийн баг сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу урьдчилсан байдлыг тухайн сургуулийн удирдлга, багш, ажилтанд мэдээлэл хийсэн.
	2019-03-26	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд өөрсдийн тайланг илгээх
	2019-03-29	Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн
Шалгуур шаардлага /журам/		БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу ажиллав.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1995 оны 11 сарын 26-нд Нүүр ам судлалын сургуулийн анхны суурь үндсийг АУИС-ийн Нүүр Ам Судлалын Төв нэртэйгээр УКТЭ-ийн тасгуудтай нэгтгэн байгуулж, нарийн мэргэжлийн гурван тэнхимтэйгээр захирал болон нүүр амны согог гажиг заслын эрхлэгчээр доктор Н.Пүрэвжав, нүүр амны эмчилгээний тэнхимийн эрхлэгчээр доктор Б.Оюунбат, нүүр амны мэс заслын тэнхимийн эрхлэгчээр Н.Оюун нар ажиллаж эхэлсэн байна.

1999 онд Нүүр ам судлалын төвийг Нүүр Ам Судлалын Сургууль болгон өргөжүүлж захирлаар Б.Оюунбат томилогдон нүүр амны эмчилгээний тэнхимийг хавсран гүйцэтгүүлэхээр, нүүр амны мэс заслын тэнхимийн эрхлэгчээр доктор Л.Давааням, нүүр амны согог гажиг заслын тэнхимийн эрхлэгчээр доктор Н.Пүрэвжав, хүүхдийн нүүр амны өвчин судлалын тэнхимийн эрхлэгчээр доктор Л.Мөнгөнцэцэг нарыг томилон дөрвөн тэнхимтэйгээр тус тус зохион байгуулсан билээ.

2005 онд НАСС-ийн захирлаар доктор Б.Амарсайхан, хүүхдийн нүүр амны өвчин судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн эрхлэгчээр Б.Оюунцэцэг нарыг томилон ажиллуулжээ. 2013 оноос доктор Г.Ариунтуул Нүүр ам судлалын сургуулийн захирлаар ажиллаж байсан. 2015 оноос НАСС-ийн Захирлаа АУ-ны доктор Ж.Отгонболд ажиллаж байна.

Тус сургууль нь 38 үндсэн багштай ба МУ-ын гавьяат эмч 1, зөвлөх 5, профессор 4, дэд профессор 11, ахлах багш 6, багш 16, дадлагажигч багш 9, АУ-ны доктор цолтой 21, АУ-ны магистр цолтой 9 багштай. Нийт багш нарын 76% нь Анагаах Ухааны Докторын зэрэгтэй бөгөөд Япон, Солонгос, Куба, Унгар, Герман, Тайвань, АНУ зэрэг улсад судалгаа шинжилгээ, нарийн мэргэжлийн сургалтад хамрагдсан.

Нүүр ам судлаач эмчийг бэлтгэх сургалтын 5 жилийн хөтөлбөрийг олон улсын стандартад нийцүүлэн 2+4 буюу нийт 6 жилийн сургалтын хөтөлбөр болгон хэрэгжүүлж байна. Нүүр Ам Судлалын Сургуулийн сургалтын хөтөлбөрийн онцлог давуу тал болох өөрийн их сургуулийн эмнэлэг дээр эмнэл зүйн сургалтыг эмчилгээ хийх орчинд багаар ажиллах загвараар сурган дадлагажуулахаар сургалтаа зохион байгуулж байна.

IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо:

Уг хөтөлбөрийг нь 1961 оноос хойш 11 удаа өөрчлөн шинэчилж хэрэгжүүлж байгаа. 2006, 2012 онд тус хөтөлбөр нь үндэсний магадлан итгэмжлэлээр магадлан итгэмжлэгдсэн.

Монгол улсын хүн амын дунд түгээмэл тохиолддог шүд цоорох өвчний тархалт, түүний эрчмийг 5, 12, 35-44, 65-74 насны бүлгүүдэд, 2014, 2016 онуудад судалсан судалгааны дүнгээс харахад хот болон аймаг орон нутгуудад шүд цоорох өвчний тархалт өндөр, шүд цоорох өвчний эрчим нь ДЭМБ-ын шалгуураар “ӨНДӨР” гэсэн түвшинд байгаа нь шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тогтмол хийгдэхгүй байгаагаас хүн амын амны хөндийн эрүүл мэндийн боловсролын түвшин хангалттай бус байна.

Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсрол, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг үндэсний тэргүүлэх болон Номхон далайн баруун эргийн бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг байхад оршино гэсэн эрхэм зорилгын хүрээнд АШУҮИС-д анагаахын суурь боловсролын стандарт хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2014-2016 онд шүдний их эмч бэлтгэх НАС-ын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан хэрэгжүүлж байна.

Шүдний их эмч мэргэжлээр төгсөгч нь дараах үндсэн 6 үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

- I Мэргэжилтэн байх
- II Мэргэжилтний харилцаа хандлага
- III Мэдлэгт суурилсан эмнэл зүйн чадвар
- IV Эрүүл мэнд, эмнэл зүйн мэдээллийг цуглуулах чадвар
- V Оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах ур чадвар
- VI Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих чадвар.

АШУҮИС-ийн хэмжээнд бакалаврын сургалтын бүх хөтөлбөрөөр төгсөгчдийн эзэмшвэл зохих мэргэжилтний цогц чадамжийг тодорхойлон тусгай ном болгосон

байна.¹ НАС-ын бакалаврын сургалтын хөтөлбөрийн төгсөгчдийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагын талаар тус номны 399-421-р талд байгаа.

НАСС-ийн шүдний их эмч бэлтгэх НАС-ын сургалтын төлөвлөгөө нь оюутны суралцах хугацаа, багц цагийн хувьд Азийн өндөр хөгжилтэй зарим орнуудын шүдний их сургуулиудын хөтөлбөртэй ойролцоо, олон улсын түвшинд дүйж очсон гэж үзэхээр байна. АШУУИС-ийн НАСС-ийн НАС-ын сургалтын хөтөлбөрийг Азийн зарим сургуулиудын хөтөлбөртэй харьцуулсан байдал:

№	Үзүүлэлт	АШУУИС-ийн НАСС	Ионсейн их сургууль	Филиппин улсын Сэбугийн их сургууль
1	Хөтөлбөрийн агуулга	Нүүр ам судлал	Нүүр ам судлал	Нүүр ам судлал
2	Хичээлийн тоо	126	129	85
3	Ерөнхий боловсролын суурь хичээлийн багц цаг	56 (27.8%)	76 (31.5%)	100 (37.8%)
4	Анагаахын болон мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн багц цаг	145 (72.1%)	165 (68.4%)	164 (62.2%)
5	Нийт багц цаг	201	241	264
6	Суралцах хугацаа	6 жил	6 жил	6 жил
7	Мэргэжлийн нэр	шүдний их эмч	шүдний их эмч	шүдний их эмч
8	Тэнхим	6	12	
9	Төгсөлтийн сургалт	M.Sc Ph.D	M.Sc Ph.D	M.Sc Ph.D
10	Төрөлжсөн мэргэжил	НАС-ын нарийн мэргэжил	НАС-ын нарийн мэргэжил	НАС-ын нарийн мэргэжил

Монгол улсад нүүр амны их эмчийн мэргэжлээр сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа Ач АУДС, Этүгэн АУДС зэрэг сургуулиудын сургалтын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг харьцуулан судалаад сургалтын хөтөлбөр ойролцоо байна гэж дүгнэжээ. Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгын бусад хэсэг, арга зүй, үнэлгээ, багшлах боловсон хүчин, сургалтын орчин нөхцөл, санхүү, менежментийн иж бүрэн хамарсан харьцуулалт судалгаа дутагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

¹ АШУУИС, Мэргэжилтний цогц чадамж УБ., 2016

- АШУҮИС-ийн хэмжээнд бакалаврын сургалтын бүх хөтөлбөрийн төгсөгчдийн эзэмшвэл зохих мэргэжилтний цогц чадамжийг тодорхойлон тусгай ном болгосон байна. НАС-ын бакалаврын сургалтын хөтөлбөрийн төгсөгчдийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагын талаар тус номны 399-421-р талд байгаа.

Зөвлөмж:

- Монгол улсын нийгэм, эдийн засаг, технологи, шүдний эмчилгээний салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийхдээ иж бүрэн хандаж байх.
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулахдаа сургалтын хөтөлбөрийн цогц шинжилгээ хийж хэвших.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Баримт нотолгоо:

НАС-ын бакалаврын сургалтын хөтөлбөр нь орчин үеийн анагаах ухааны нотолгоонд суурилсан, нэгдмэл сургалтын үзэл баримтлалтай.

АШУҮИС-ийн эрхэм зорилго болох “Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх, Номхон далайн баруун эргийн бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг байхад оршино” хэмээн тодорхойлсон зорилготой уялдуулан олон улс буюу үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чадвар, хандлагатай, эзэмшсэн мэргэжлээрээ эрүүл мэндийн салбарт ажиллах боломж нь нээлттэй шүдний их эмч мэргэжилтэн бэлтгэх нь НАСС-ийн эрхэм зорилгын нэг гэж тодорхойлсон байна. Судалгаа, сургалт, эмнэл зүйн үйл ажиллагааны нэгдлийг хангаж, оюутны суралцах орчин болон эмчилгээ үйлчилгээ явуулах таатай нөхцөл бүрдүүлж чанартай мэргэжилтэн бэлдэх нь НАСС-ийн эрхэм зорилго бөгөөд тус сургуулийн алсын хараа: “Азидаа танигдсан, Дэлхийд хүндлэгдсэн сургууль” болоход чиглэнэ гэж тодорхойлсон байна. Сургалтын үзэл баримтлал, сургуулийн эрхэм зорилго, алсын хараандаа чиглүүлэн асуудалд, чадамжид, харилцаанд, даалгаварт, тохиолдолд суурилсан арга, дадлага, эмнэл зүйн эмнэлгийн орчин, интерактив лекц зэрэг сургалтын арга зүйг хэрэгжүүлж үндэсний болон олон улсын стандартад нийцсэн мэдлэг, чадвар, хандлагатай мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Тухайн сургалтын хөтөлбөр нь тогтсон үнэлгээний системтэй байна.

Төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч сонирхогч талуудын саналыг тусгаж хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Азидаа танигдсан, Дэлхийд хүндлэгдсэн сургууль” болоход чиглэсэн сургуулийн алсын хараа хүрээнд “Нүүр ам судлал” бакалаврын сургалтын хөтөлбөр үйл ажиллагаагаа зохион байгуулж байна

Зөвлөмж:

- Төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч сонирхогч талуудын саналыг тусгаж хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

БШУС-ын 2014 оны А174, А178 тоот тушаалыг мөрдлөг болгон тус сургалтын хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулж мөрдөн ажиллаж байна. Тус хөтөлбөр нь 201 багц цаг судлахаар төлөвлөгдсөн бөгөөд дадлага, практик үйлийн тал давамгайлсан байдлаар 2016 онд шинэчлэн батлуулж хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн онол практикийн харьцааг хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 1. Хөтөлбөрт тусгагдсан онол, практикийн харьцаа

	2010 оны төлөвлөгөө			2016 оны төлөвлөг өө			Зөрөө	
	Цаг	Багц цаг	Харьц аа	Цаг	Багц цаг	Харьцаа	Цаг	Багц
Цаг	471 2	180		964 8	201		4936	
Лекц	105 6	66	1	117 2	73	1	116	7
Семинар	440	13.5	0.42	487	15.2	0.42	47	1.7
Дадлага	267 2	83.5	2.53	257 9	80.8	2.2	-93	- 2.7
Бататгах	-		0	102	32	0.87	102	32
Бие даалт	544	17	0.52	438 8	-	3.74	3844	-17

Хүснэгт 2. НАС-ын сургалтын хөтөлбөрийн онол, дадлагын хичээлийн харьцаа

	Багц цагийн агуулга	Онолын хичээл				Дадлагын хичээл				Бие даалт			
		2010 он		2016 он		2010 он		2016 он		2010 он		2016 он	
		Нийт цаг	Эзлэх хувь	Нийт аг	Эзлэх хувь	Нийт цаг	Эзлэх хувь	Нийт цаг	Эзлэх хувь	Нийт цаг	Эзлэх хувь	Нийт цаг	Эзлэх хувь
1	Ерөнхий суурь	256	24.2	340	29	288	10.7	1112	27.2	320	58.8	1236	28.1
2	Мэргэжлийн суурь	480	45.5	338	28.8	832	31.3	796	19.5	16	2.9	1042	23.7
3	Мэргэшүүлэх	320	30.3	494	42.1	1552	58	2180	53.3	208	38.2	2110	48.1
	Нийт дүн цаг/багц цаг	1056 (66)	100	1172 (73)	100	2672 (83)	100	4088 (127)	100	544 (17)	100	4388 (137)	100

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн хөтөлбөр нь “Нүүр ам судлал” бакалаврын сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал харьцангуй жигд байгаа нь “Амны салстын өвчин”, “Хүүхдийн нүүр ам судлал 1,2,3,4”, Хүүхдийн нүүр ам судлалын эмнэл зүйн удиртгал 1,2”, “Хүүхдийн зан үйл судлал”, “Нүүр амны мэс засал” хичээлийг заадаг багш нартай ярилцах, хичээлийн хөтөлбөр, үнэлгээний хэрэглэгдэхүүнтэй танилцахад ажиглагдаж байлаа.

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрийн агуулгын төлөвлөлтийн чухал илрэл болох сургалтын төлөвлөгөөгөө багц цагаар биш, цагаар төлөвлөдөг нь төвөгтэй байдал үүсгэх магадлалтай. Тухайлбал: энэ хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд багц цагаар хичээл судалж тооцоо хийж байгаа атлаа багш нарын ачааллыг цагаар, оноогоор төлөвлөж санхүүгийн асуудлаа шийдвэрлэж буй нь нэлээд төөрөгдүүлэх байдалтайг цэглэх хэрэгтэй байна.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Баримт нотолгоо:

- НАСС нь сургуулийн зориулалтаар баригдсан хичээлийн шинэ байртай болсон.
- 2017 онд Нийслэл хотод Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төвийн шинэ эмнэлэг ашиглалтанд орсон ба уг төв нь НАСС-ийн түшиц эмнэлэг юм.
- Сургуулийн шинэ байр болон түшиц эмнэлэг шинээр ашиглалтанд орсонтой холбогдуулан хичээлийн суралцах орчин, эмнэл зүйн сургалтын нөхцөл сайжирсан. Мөн эмнэл зүйн дадлагын хичээл явуулах лабораторийн орчин, техник тоног төхөөрөмж сайжирч, багш сурагчдын өрөөний тоо нэмэгдэж нэг оюутанд ноогдох талбайн хэмжээ 1.2 м.кв-аар нэмэгдсэн.
- Багш, оюутнуудын аюулгүй байдлыг хангах зорилгоор сургуулийн хэмжээнд камерын хяналтын сиситемийг суурилуулсан.
- Оюутнуудын ариун цэврийн өрөөний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- НАСС-ийн дэргэд сургуулийн эмнэлгийн өргөтгөл баригдаж эмнэл зүйн сургуулийн суралцах орчин 1600 м.кв-аар нэмэгдсэн.
- 20-25 оюутан тутумд 1 ариун цэврийн өрөө, 30-35 оюутан тутамд 1 угаалтуур ноогдож хүртээмж нэмэгдсэн.
- Мөн эмнэл зүйн дадлагын хичээл явуулах лабораторийн орчин, техник тоног төхөөрөмж сайжирч, багш суралцагчдын өрөөний тоо нэмэгдэж нэг оюутанд ноогдох талбайн хэмжээ 1.2 м.кв-аар нэмэгдсэн.
- 20-25 оюутан тутамд 1 ариун цэврийн өрөө, 30-35 оюутан тутамд 1 угаалтуур ноогдож хүртээмж нэмэгдсэн.

Зөвлөмж:

- Оюутнууд хичээлийн бус цагаар сургууль дээрээ хичээлээ давтахад нь сул өрөө тасалгааг ашиглах боломжоор хангах шаардлагатай.

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Анагаахын судалгааны чиглэлийн програм хангамжуудыг хөтөлбөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.
- Сургуулийн шинэ байртай болсноор хөтөлбөрийн хүрээнд эмнэл зүйн дадлагын лабораторийн тоног төхөөрөмжийн тоо, чанар нэмэгдсэн. Хангамжийн үйл явц нь тасралтгүй байхаар удирдлага зохион байгуулалтаар хангасан.
- НАСС-ийн <http://dentistry.mnnums.edu.mn/> цахим хуудсанд нэвтэрч үзэхэд цахим хуудас нээгдэж байхаас гадна сургуулийн тухай мэдээлэл, багш, оюутнудад зориулсан хандалтын хэсгүүд мөн мэдээ мэдээллийн хэсэгт багш, оюутнуудад зориулсан мэдээлэл байршсан. Харин цахим хуудсыг тасралтгүй хөтлөх үйл ажиллагаа учир дутагдалтай. Учир нь 2019 оны 01-р сарын 19-нээс хойш мэдээлэл шинэчлэгдэж ороогүй.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ UNIMIS (CLOUD UNIVERSITY)мэдээлэлийн удирдлагын системийг шинээр нэвтрүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн шинэ байртай болсноор хөтөлбөрийн хүрээн дэх эмнэл зүйн дадлагын лабораторийн тоног төхөөрөмжийн тоо, чанар нэмэгдсэн. Хангамжийн үйл явц нь тасралтгүй байхаар удирдлага зохион байгуулалтаар хангасан.
- АШУИС-ийн төв байранд багш, оюутнуудад зориулсан цахим сургалтын “E-Learning center” тогтмол ажилладаг. Уг цахим сургалтын төвд зарим 1-2 курсийн ерөнхий мэргэжлийн зарим хичээлүүдийг онлайн хэлбэрээр зайнаас судлах боломжийг бүрдүүлсэн.
- Оюутнуудад лаборатори, урлангийн өрөөнд ажиллах мэдлэг, чадвар хандлагыг эзэмшүүлэх үүднээс шинээр симуляци лаборатори, эмнэл зүйн ур чадварын лабораторийг ашиглалтанд оруулсан.

Анхаарах асуудал:

- UNIMIS (CLOUD UNIVERSITY) програм нь багш, оюутнуудад өдөр тутам ашиглахад тохиромжгүй, үйл ажиллагаатай нь уялддаггүй.

- Сургалтын хөтөлбөрт ордог сурах бичиг, дадлагын ажлын аргачлал, гарын авлагын тоог нэмэгдүүлсэн хэдий ч сурах бичгийн 70 хувь бүрэн шинэчлэгдээгүй.

Зөвлөмж:

- UNIMIS (CLOUD UNIVERSITY) програмын дутагдалтай талуудыг сайжруулан, багш, оюутнууд өдөр тутмын сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж болохуйц болгох.

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Сургуулийн номын сангийн суудлын тоог 130 болгож нэмэгдүүлсэн.
- Анагаах ухааны орчин үеийн олот амжилт, судалгаа шинжилгээний бүтээлийг өөртөө агуулсан ном, сэтгүүл, сурах бичгийн тоог нэмэгдүүлсэн.
- АШУУИСургууль шинэ номын сантай болсон.
- Цахим номын сангийн Uniface 5.0 программ хангамжийг хөгжүүлж их сургуулийн удирдлагын системийн номын сангийн модулийг нэвтрүүлсэн.
- Цахим номын сангийн техник, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилсэн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- HINARI хандалт, БСШУЯ-ны төслөөр Springer, Ensco Host мэдээллийн сангуудыг ашигласан.
- 2015 онд олон улсын Сайбер их сургуулийг байгуулсан нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сургалт зохион байгуулсан.
- Цахим хичээлийн Мультимедиа студийг зохион байгуулсан.
- Сүүлийн 5-н жилд нийт төгсөлтийн өмнөх сургалтад давхардсан тоогоор 50 гаруй цахим хичээлд, 6000 гаруй оюутнууд, төгсөлтийн сургалтын 18 хичээлд, 328 магистрант болон багц цагийн суралцагч нар хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- АШУИС шинэ номын сантай болсон хэдий ч НАСС-ийн орон зайн байрлалаас шалтгаалж НАСС-ийн оюутнууд төв сургуулийн номын санг ашиглахад хүндрэл бэрхшээлтэй байгаа асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

- НАСС-ийн сургалтын үндсэн сурах бичиг дутагдалтай, хүртээмж муу байгааг нэмэгдүүлэх шаардлагатай.

Зөвлөмж:

- НАСС өөрийн хичээлийн байран дахь номын сангийн үйл ажиллагааг өргөтгөж, сургалтад ашиглагдах номын фондыг нэмэгдүүлэх, АШУҮИС-ийн төв байрны номын сангийн онлайн мэдээллийн санг цахим сүлжээгээр орон зайнаас үл хамааран авах боломжийг мэдээллийн технологийн тусламжтайгаар бүрдүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн үндсэн сурах бичгийн тоог нэмэгдүүлэх, номын сангийн хүрэлцээг хүртээмжтэй болгох
- Тэнхим бүр өөрийн хичээлд ашигладаг сурах бичгээс төрөл бүрээс нь 2-3 ширхэгийн нөөцийг үүсгэж оюутнуудад ашиглуулах боломжийг бий болгох.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

- АШУҮИС-ийн бизнес төлөвлөгөөний “НЭЭЛТТЭЙ ИХ СУРГУУЛЬ” байх стратеги зорилтын хүрээнд их сургуулийн удирдлага мэдээллийн систем UNIMIS-г АШУИС-ийн захирлын 2015 оны 05-р сарын 6-ны өдрийн А/55 тоот тушаалаар нэвтрүүлэн ажилладаг. Уг систем нь Сургалтын бодлого зохицуулалтын газар, багш, суралцагчид, суралцагсдын эцэг, эх хоорондын харилцаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглаж ажлын бүтээмжийг дээшлүүлэх, сургалтын мэдээллийн нэгдсэн санг бий болгох үндсэн зорилтын хүрээнд ашиглагддаг.
- НАСС-ийн бүх тэнхимүүд, сургалт, эрдэм шинжилгээ, оюутан, багшийн мэдээллийн дэд системд холбогдсноор нэгтгэгдэх нөхцөл бүрдэж нэгдсэн төвд мэдээллийг хадгалах, хамгаалах, нэгтгэх, хянах боломжтой болсон.
- АШУҮИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн болон харьяа сургуулиудад сургалтын “UniFACE 5.0” программ хангамжийг нэвтрүүлсэн бөгөөд урьд нь ашиглаж байсан програм дахь мэдээллийн баазыг хуулж авч “UniFACE 5.0”-д хөрвүүлснээр шинээр 5 модуль нэмэгдсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд UNIMIS-ийн дараах дэд програмуудыг ашиглах болсон: админы програм, монитор програм, сургалтын бодлого зохицуулалтын албаны програм, багшийн програм, оюуты програм.
- АШУҮИС-ийн захирлын 2016 оны А/56 тоот тушаалаар “Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг баталсан. Хөтөлбөрийн хороо нь АШУҮИС-ийн төгсөлтийн өмнөх, төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрүүдийн хүрээнд ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх, сонгон судлах хичээлд тавих шалгуур үзүүлэлт, хичээлийн хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулах мэргэжлийн үнэлгээ хийж, хоорондын уялдаа холбоо, агуулгын давхардал, хэрэгцээг тодорхойлж бодлого зөвлөмж түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэрийг гаргадаг болсон.
- НАСС-ийн дадлагын хичээлийн гардан үйлдлийн, бие даалтын ажлыг бүртгэх хуудасны ард тухайн хичээлээр ямар санал, гомдол байгааг бичүүлж авдаг тогтолцоо бүрдсэн.
- Тэнхим бүрт хүний нөөцийн судлагаа хийгдэж, төлөвлөгөөтэйгөөр шинээр дадлагажигч багшийг АШУҮИС-ийн Багшийн хөгжлийн төвд суралцуулж, туршлагатай эрдэмтэн багш, профессоруудын лекц дадлагын хичээлд суулган, жил бүр аттестатчлалд оруулж үнэлгээг үндэслэн зэрэглэл тогтоодог системтэй.

Анхаарах асуудал:

- АШУҮИС нь бүрэлдэхүүн сургуулиудыг байгуулсан хэдий ч хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалтын тухайд бүрэн даалгасан үйл ажиллагаа учир дутагдалтай, удирдлагын эрх мэдлийг гүйцэд шилжүүлээгүй.

Зөвлөмж:

- АШУҮИС нь бүрэлдэхүүн сургуулиудаа удирдлага, зохион байгуулалтын хувьд бүрэн бие даасан болгох эрх зүйн зохицуулалтыг хийх

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Баримт нотолгоо:

- Зах зээл дээрээс бүтээгдэхүүн нэмэгдүүлэх бодлогын хүрээнд:
- Бусад ижил төрлийн үйл ажиллагаатай их сургуулиудаас элсэгчдийн тоог харьцуулан гаргаж шилжин ирэх хүсэлтийн тоог гаргаж тооцоолол хийдэг.
- Бусад ижил төрлийн үйл ажиллагаатай их сургуулийн хөтөлбөртэй харьцуулдаг.

- Мэргэжлийн болон нээлттэй хаалганы өдрөөр ирэх тоог нэмэгдүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шүдний их эмчийн мэргэжлийг болон НАСС-ийг сурталчлах зорилгоор олон нийт болон суралцагчдад сургуулийн цахим хуудас ашиглан мэдээлэлийг түгээдэг.

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Баримт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгааны хүрээнд хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой ажиллаж тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулдаг.
- 2011-2013 онд шүдний их эмч бэлтгэх НАС-ын хөтөлбөрөөр төгссөн оюутнуудын дунд ажил эрхлэлтийн байдлыг харахад нийт төгсөгчдийн 84.6 хувь нь ажлын байртай болсон.
- Төгсөлтийн дараах үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон төгсөгчдийг давтан сургалтанд хамруулах бодлого, төлөвлөлт хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016 оноос цахим болон боловсролын магистрантурын сургалтын хөтөлбөрөөр шинээр элсэлт авдаг болж нийт 284 оюутан элсэн орсноос НАС-ын чиглэлээр 39 суралцагч байсан.
- НАСС-ийн дэргэд 2015 онд НАСС-ийн төгсөгчдийн холбоо байгуулагдан төгсөгчдийн дунд богино болон урт хугацааны цахим сургалт зохион байгуулах, ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулах, эмч нарын ажил эрхлэлтийн судалгааг хийж, ажлын байрны санал авч зуучлах үйл ажиллагааг явуулдаг.

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

- 2013-2017 онд НАС-ын сургалтын хөтөлбөрийн хүрээнд гадаадын болон олон улсын төрийн бус байгууллага, их дээд сургууль зэрэг давхардсан

тоогоор 59 нэгжтэй хамтарч шинээр 6 нэгжтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.

- НАСС-ийн багш нар гадаадад урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлэх сургалтанд жилд дунджаар 10 удаа хамрагдсан байна.
- Мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд гадаадын мэргэжилтэн, багш хичээл заадаг болсон төдийгүй жил тутам гадаадын зочин профессорыг урьж байна.
- Жил бүр дунджаар 5-40 оюутанд АШУУИС-ийн хүндэт профессор Жи Хеүн Тейкийн нэрэмжит тэтгэлэг олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- АШУУИС-ийн гадаадын хамтран ажилладаг их сургуулиудтай хамтарсан судалгаа хийх, урт богино хугацаагаар сургалтад хамруулах үйл ажиллагааг багш, ажилтнуудыг дунд нээлттэй ил тод зарладаг тогтолцоог бүрдүүлсэн.

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

- Дотоод хамтын ажиллагааны хүрээнд сургалт, эмнэл зүй, мэргэжлийн 15 нийгэмлэг, холбоодын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж нийгэмд хандсан хүмүүнлэгийн ажлуудыг хийж байна.
- 2011-2016 оны хооронд нийт 15 төсөлт ажил хэрэгжиж, түүнтэй уялдсан ижил тооны бүтээл хэвлүүлэхээр төлөвлөснөөс 20 гаруй бүтээл хэвлэгдсэн. АШУУИС-ийн бодлогын хүрээнд дотоод харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор АШУУИС-ийн “Хөгжлийн бодлого 2015-2024”-тэй төсөлт ажлуудыг уялдуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ЭМСайдын 2018 оны 03 тоот тушаалаар “Эрүүл хүүхэд-эрүүл шүд” үндэсний хөтөлбөрийг боловсруулах мэргэжлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлсэн, зөвлөмж өгч ажилласан.
- 2018 онд Улаанбаатар хотын ЕБС-ын нийт 40 сургуулийн шүдний кабинетийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэргэжлийн сургалтыг шүдний эмч нарт явуулсан.
- НАСС-ийн багш нар 2018 онд Төвийн бүсийн буюу Эрдэнэт, Дархан, Хөвсгөл аймгийн мэргэжилтнүүдэд “Нүүр амны тусламж үйлчилгээ,

оношилгооны тулгамдсан асуудлууд” сэдэвт сургалтыг орон нутгийн эмч нарт явуулсан.

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрт зориулсан төсвийн зарцуулалт жил бүр тогтмол нэмэгдэж байна
- Төсөв санхүүгийн бие даасан байдлыг тодорхойлохын тулд АШУУИС-ийн НАСС-ийн 2013, 2014, 2015, 2017 оны төсөв түүний зарцуулалт, нэг оюутанд ноогдох зардлыг сүүийн 5 жилээр товчоолоход:

№	Төсөв	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
1	Орлого	12060.0	202980.0	1.531.531.0	1.639.057.0	
2	Зарлага	437824.7	695536.6	1.569.447.9	2.632.218.4	

№	Орлогын төрөл	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
1	Бакалаврын сургалтын төлбөр	179280.0	155002.6	278289.2	205364.4	269712.0
2	Магистрын сургалтын төлбөр	54337.5	10062.5	14490.0	38640.0	19320.0
3	Доктрантурын сургалтын төлбөр	7360.0	9813.2	11776.0	8832.0	11776.0
4	Резидентын сургалтын төлбөр	43560.0	33280.0	59072.0	64064.0	64064.0
5	Курс дамжааны төлбөр	2.912.000	=	1,040,000	1,040,000	1248,000

№	Орлогын төрөл	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
1	Сургуулийн эмнэлгийн орлого	357.865.400	473.933.100	551.025.710	607.141.500	766.642.550
2	Төсөл хөтөлбөрийн орлого	20.000.000		45.900.000 743.129\$		50.000.000
3	Хандив тусламж	=	2800,000	=		8250,000

- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

№	Үзүүлэлт	2013-2014 он	2014-2015 он	2015-2016 он	2016-2017 он	2017-2018 он
1	Оюутны тоо	96	83	133	106	144
2	Төлбөрийн дундаж	1867.5	1867.5	2092.4	1937.4	1873.3
3	Нийт орлого	179280.0	155002.6	278289.2	205364.4	269712.0

Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв: Төсөв, санхүүжилтээс хөтөлбөрийн үр дүн, шинэчлэл, өөрчлөлтөнд зориулсан

дараах чиглэлүүдийн зарцуулалт сүүлийн 3 жилд тогтмол, их хэмжээгээр нэмэгдсэн. Үүнд:

№	Орлогын төрөл	2013-2014 он	2014-2015 он	2015-2016 он	2016-2017 он
1	Хичээлийн үзүүлэн, таниулах, матеиал авах	23074,5	33372.4		71.492.5
2	Сургалтад хэрэглэгдэх эм урвалж авах	=			20.000.0
3	Оюутанд чиглэсэн, оюутны хөгжилд зарцуулсан үйл ажилгааны зарцуулалт	=	1466.0		
4	Гадаад харилцаа холбоог сайжруулахад зориулсан зардал			911,9	

- НАСС-ийн төсвийн уламжлалт бус санхүүжилт дараах эх үүсвэрүүдээс бүрдэж байна. Үүнд:
 - Оюутны хичээл нөхөлтийн төлбөр / хичээлийн явцад/
 - Оюутны өвлийн дахин сургалт
 - Оюутны зуны дахин сургалт
 - Оюутны дахин шалгалтын төлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- АШУҮИС–ийн бүрэлдэхүүн сургуулиудынхаа санхүүгийн бие даасан байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг 2019 оны 01-р сарын 01-нээс хийхээр шийдвэр гаргасан.

Анхаарах асуудал:

- НАСС-ийн санхүүгийн гол эх үүсвэр нь АШУҮИС-иас хувиарлаж буй төсөв бөгөөд сургуулийн санхүүгийн бие даасан байдал нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд харьцангуй дутмаг байна.
- Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглэгдсэн хэтийн төлөвлөгөөг тодорхой цаг хугацаатай төлөвлөх, хөрөнгө оруулалт, хандив тусламжийн хэмжээг тодорхой зааж тусгаж байх, санхүүгийн төлөвлөлтийн гүйцэтгэлийн хяналтыг тогтмол хийдэг байх, явцыг хэлэлцэж шийдвэр гаргадаг байх шаардлагатай.

Зөвлөмж:

- НАСС-ийн төсвийн зарцуулалтыг шилэн дансны хуулийн дагуу уялдуулж төсвийн зарцуулалтын нээлттэй ил тод байх зарчмыг баримталж ажиллах.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Баримт нотолгоо:

- АШУҮИС нь 2014-2017 онд элсэгчдийг анагаахын суурь боловсролын нэгдсэн хөтөлбөрийн дагуу 2 жил сургалтад хамруулан тухайн суралцагчийн сонирхлын үндсэн дээр НАС-ын хөтөлбөрөөр суралцах суралцагчийг шалгаруулж элсүүлдэг.
- Журамд заасан босго оноог давсан хэн бүхэнд бүртгэл нээлттэй ил тод явагддаг бөгөөд бүртгэгдсэн суралцагчдын жагсаалтыг АШУҮИС-ийн оюутны албанаас онооны дарааллаар гарган мэргэжил сонгох үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- АШУҮИС нь тухайн хичээлийн 1 дүгээр дамжаанд элссэн оюутнуудад зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох “Удиртгал-07” хоногийн хичээлийг Оюутны албатай хамтран сургуулийн танилцуулга, сургалттай холбоотой дүрэм, журам, харилцаа, ёс зүй, эрүүл мэнд, мэдээллийн систем оюутны программ, номын сан танилцуулах зэрэг сургалтыг явуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- НАС-ын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд багш нарын саналыг үндэслэн 2016 оны АШУҮИС-ийн захирлын тушаалаар шүдний их эмч бэлтгэх НАС-ын хөтөлбөрийг 2+4 болгон батлуулж эмнэл зүйн ур чадвартай мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэж байна.

4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Баримт нотолгоо:

- НАС-ын хөтөлбөрөөр суралцагчдад хүснэгт 4.2.1 –д заагдсан хуваарийн дагуу суралцах, судалгааны арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол үзүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- НАС-ын хөтөлбөрөөр суралцагчдад хүснэгт 4.2.1 –д заагдсан хуваарийн дагуу суралцах, судалгааны арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол үзүүлдэг.

Зөвлөх хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн
НАСС-ийн суралцагчдад суралцах, судалгааны арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол үзүүлж байна.

Суралцагчдад зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх хуваарь Хүснэгт 4.2.1

Д/д	Зөвлөн туслах үйлчилгээ	Мэргэжилтэн	Цагийн хуваарь
1	Суралцагчдад суралцахад зөвлөн туслах үйлчилгээ	Дадлага, семинар орж буй багш нар	Даваа – Баасан
2	Оюутанд судалгаа хийх, арга зүйн зөвлөгөө өгөх	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	Даваа - Баасан
3	Ирээдүйн ажил мэргэжилд зөвлөгөө өгөх	НАСС -ийн Төгсөгчдийн холбоо	Даваа - Баасан
4	Оюутны хөдөлмөр эрхлэх боломжийг зөвлөх	НАССОЗ	Даваа - Баасан
5	Оюутны бие даан суралцах нөхцлийг сайжруулах	Клуб, нийгэмлэгүүд	Даваа - Баасан
6	Оюутны тодорхойлолт, тэтгэлэг урамшуулал	Оюутны алба	Даваа, Лхагва, Пүрэв, Баасан
7	Сургалтын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол	Сургалтын алба	Даваа, Лхагва, Пүрэв, Баасан

Оюутны программ
2004 оноос эхлэн Uniface (Их Сургуулийн Удирдлага Мэдээллийн Систем)- ийг сонгон авч сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлээд 2015 оноос UNIMIS цогц программ хангамжийг шинээр нэвтрүүлсэн. Үүний давуу тал нь оюутнууд хүссэн мэргэжлийн багшаасаа мэдээлэл, зөвлөгөө авах, сургалтын нэмэлт мэдээлэл, тэтгэлэг болон уралдаан тэмцээний мэдээлэл авах боломжтой.

Анхаарах асуудал:

- Оюутанд чиглэсэн үйлчилгээний чанарыг үнэлэх үнэлгээний судалгааг тогтмол хийж, судалгааны үр дүнг үндэслэсэн ажлуудыг оюутнуудын дунд зохион байгуулах шаардлагатай.
- Оюутнуудын хандлагыг өөрчилөхөд чиглэсэн оюутны хөгжлийг хангах чиглэлийн ажлыг сургуулийн удирдлага зохион байгуулалтаар хангадаг үйл ажиллагаа сул.

4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:


- НАС-ын хөтөлбөр нь Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин АШУҮИС-ийн Оюутны алба нь оюутны өөрөө удирдах дээд байгууллага бөгөөд оюутанд чинлэсэн тусгайлсан хөтөлбөрийг

боловсруулж, төлөвлөгөө гарган ажилладаг. НАСС-ийн сургууль дээр өөрийн оюутны зөвлөл ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- НАСС нь 4 тэнхим, 4 мэргэжилтэн бэлтгэн гаргадаг бөгөөд мэргэжлийн чиглэл бүрээр оюутны сонирхлыг дэмжсэн 6 төрлийн клубууд тогтмол ажилладаг.



Анхаарах асуудал:

- НАСС-ийн Оюутны зөвлөлийн өрөөг тусад нь зохион байгуулж, бие даан ажиллах орчин нөхцлөөр хангах шаардлагатай.

Зөвлөмж:

- НАСС-ийн оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээний төсвийг хувиарлаж байх нь зүйтэй.

4.4. Суралцагчийн урамшлууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Баримт нотолгоо:

- АШУУИС нь НАСС-д суралцаж буй оюунлаг, авьяаслаг, тэргүүний оюутнууд түүнчлэн амжилттай суралцаж байгаа хэдий ч амьдралын боломж муутай суралцагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг гадаад, дотоодын хувь хүн, байгууллагын 30 гаруй төрлийн тэтгэлэгт хамруулах боломжийг олгодог системтэй.
- 2015-2017 оны хооронд АШУУИС-ийн хэмжээнд гаргасан санхүүгийн дүгнэлтээс харахад нийт 30 төрлийн тэтгэлгээс НАСС-ийн 85 оюутан нийт 16 төрлийн 70.058.850 төгрөгний тэтгэлэгт хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- АШУҮИС-ийн Оюутны албаны тайлан мэдээнээс харахад 2017 онд 238.250.000 төгрөгний тэтгэлэг, тусламжийг 263 оюутанд олгосон бол 2018 онд нийт 19 тэтгэлэгт хөтөлбөр 424 оюутан хамрагдсан байна.

Зөвлөмж:

- Оюутны тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахдаа оюутны нийгмийн байдлын үнэлгээний хүчин зүйлийг илүүтэйгээр авч үзэх нь зүйтэй.

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Баримт нотолгоо:

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг АШУҮИС-ийн захирлын 2015 оны 12 сарын 14-ний өдрийн А/142 тушаалын хавсралт 2 батлагдсан төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 4-т заасан “Оюутны шилжилт хөдөлгөөн”-ийг зохицуулах журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэдэг.
- 2018-2019 оны хичээлийн жилд шилжилт хөдөлгөөнтэй холбоотой АШУИС-ийн захирлын 3 тушаал батлагдсан ба шилжилт хөдөлгөөний журмын дагуу НАСС-ийн 29 оюутны хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого
Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой

хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

- Сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт

Багш бэлтгэх, сонгон шалгаруулах, ажилд авах асуудал АШУҮИС-ийн захирлын 2016 оны 11 сарын 9-ны өдрийн А/118 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагааг зохицуулах журмын 3-т заасны дагуу ажилд шинээр авах багшийн сонгон шалгаруулалтын дагуу нэгдсэн бодлоготой хийгддэг байна. АШУҮИС-ийг шинэчлэх, хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд /2015-2024/ оновчтой бүтэцтэй, чадварлаг багш, судлаачидтай шилдэг их сургууль байх стратеги зорилтын хүрээнд чадварлаг боловсон хүчин, баг бүрдүүлэх ажлыг тэргүүн зорилт болгон тавьсан байна. Сонгон шалгаруулалтад оролцогчдод шинжлэх ухааны магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, тухайн мэргэжлээр эмнэлзүйн салбарт 3 жилээс дээш, бусад салбарт 2 –оос дээш жил ажилласан, туршлагатай компьютерийн хэрэглээний программыг бүрэн эзэмшсэн байх зэрэг шаардлага тавигддаг байна. Сонгон шалгаруулалтыг Сургалтын бодлого зохицуулалтын газар, Багшийн хөгжлийн төв зохион байгуулдаг. Багшийг шалгаруулж авахдаа тэнхимийн цагийн ачаалал, хэрэгцээг тодорхойлсон тэнхимийн эрхлэгч, бүрэлдэхүүн сургуулийн захирлын тодорхойлолт дээр үндэслэдэг байна. Шаардлага хангасан оролцогчдоос мэргэжил, англи хэлний шалгалтыг нэгдсэн зохион байгуулалтаар авдаг байна. Шалгалтыг сорил, аман хэлбэрээр авдаг.

- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин

Шүдний их эмч бэлтгэх НАС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд ерөнхий ба мэргэжлийн суурь хичээл заадаг 145 багш, мэргэшүүлэх хичээлийг 41 багш зааж нийт 186 багш хөтөлбөр хэргжүүлэхэд оролцож байна. Ерөнхий ба мэргэжлийн суурь хичээл заадаг багш нарын 8% нь профессор, 14% нь дэд профессор, 17% нь ахлах багш, 38% нь багш, 21% нь дадлагажигч багш байгаа бол мэргэшүүлэх хичээл заадаг багш нарын 8% профессор, 17% нь дэд профессор, 45% нь АУ-ны доктор, 30% нь АУ-ны магистр байна. 2011 он буюу 2 дох магадлан итгэмжлэлийн үетэй одоогийн багш нарын эрдмийн зэрэг цолыг харьцуулахад профессор 1, дэд профессор 2, АУ-ны доктор 2, АУ-ны магистр 11-р нэмэгдсэн байна. Багшийн албан тушаалын зэрэглэлээс харахад 2011 онд дадлагажигч багш 5, багш 8, ахлах багш 7, дэд профессор 5, профессор 2 байсан бол 2017 оны байдлаар дадлагажигч 9, багш 14, ахлах багш 7, дэд профессор 7, профессор 3 болж албан тушаалын зэрэглэл ахисан байна. Мэргэжлийн зэрэгтэй багш нар 2011 онд 8 байснаас 2 нь ахлах, 6 нь тэргүүлэх зэрэгтэй байсан бол 2018 оны байдлаар зөвлөх зэрэгтэй 4, ахлах зэрэгтэй 9, тэргүүлэх зэрэгтэй 10 болж зэрэгтэй багш нарын эзлэх хувь эрс нэмэгдсэн байна.

- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа

Боловсролын үйл ажиллагааг чанаржуулахын хүрээнд 1 багшид ноогдох оюутны тоог 2015-2024 онд 1:21-ээс 1:12 хүргэх үе шаттай бууруулах төлөвлөлт хийсэн

байна. 2016-2017 оны хичээлийн жилд 3-6 –р дамжааны нэг хэсэгт ноогдох оюутны тоог 14-15 болгож цөөлсөн байна. БСШУСЯ-ны сайдын 2007 оны 3 сарын 13-ны өдрийн 74 тоот тушаалд анагаахын чиглэлийн дээд боловсролын байгууллагын 1 багшид ноогдох оюутны тоо 8-10 байна гэсний дагуу багш оюутны харьцаа 2014 онд 1:21, 2015 онд 1:20, 2016 онд 1:19 буурсан байна. 2024 он гэхэд багш оюутны харьцааг 1:12 болгохоор төлөвлөсөн байна.

- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал

Багшийн гүйцэтгэх ачааллыг багц цагаар тооцдог байсан бол 2014 оноос онооны системд шилжсэн байна. Албан тушаалын зэрэглэл харгалзахгүй ачаалал 1600 оноо. Энэ оноо нь долоо хоногийн ажлын цаг 40-өөр тооцож, хичээллэх 40 долоо хоногт үржүүлсэнтэй тэнцэнэ. АШУҮИС-ийн захирлын 2016 оны 6 сарын 10-ны өдрийн А/72 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан багшийн ажлын гүйцэтгэлийнг үнэлэх журамд багш мэргэжилтэн, багш судлаач, багш багшийн орон тоо бий болгож, түүнд тохируулан онооны хуваарилалт хийдэг байна. Жиш: профессор /багш судлаач/ 1600 онооны 1012-ыг ЭШ, МҮА –нд зарцуулдаг бол сургалтанд үлдсэн цагийг, гэтэл багш багшийн сургалт, ЭШ, МҮА-д зарцуулах цаг тэнцүү /50%/ байна.

- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

АШУҮИС нь багшлах боловсон хүчинд бүтээлийн чөлөө олгох, докторантын сургалтын төлбөрийг хөнгөлөх, тэнхимийн эрхлэгч нарт цагийн ачааллаас хөнгөлөх, орон тооны бус албан үүргийг хавсран гүйцэтгэвэл цагийн ачааллаас хөнгөлөх зэрэг олон хөнгөлөлт үзүүлдэг байна. Мөн Томсон Ройтерсийн индекс бүхий олон улсын сэтгүүлд 1-р зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн бол индексийн онооноос хамааран жилд 1 удаа 100000-500000 хүртэл төгрөгийн урамшуулал олгодог байна. Төлбөрөө бүрэн төлсөн, хугацаандаа магистр, доктор хамгаалсан хүний тоогоор тухайн тэнхимд магистрт 100000, докторт 200000 төгрөг олгох урамшуулалтай боловч мөнгөн урамшууллын оронд ахуйн эд материал олгодог байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Багш сонгон шалгаруулах (журамд заасны дагуу мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан хүнийг авах)
- Тухайн мэргэжлийг эзэмшсэн ч эмнэлзүй дээр ажиллаж байгаагүй багш нарыг богино хугацаанд дадлагажуулах, ангийн сургалт явуулахгүй байхад анхаарах

Зөвлөмж:

- Багш шалгаруулж авахад мэргэжлийн шалгалт, ярилцлагад тухайн мэргэжлийн тэнхимийн эрхлэгчийг оруулдаг байх
- Багш нараас гардан үйлдлийн шалгалтыг заавал авч байх
- Төлбөрөө бүрэн төлсөн, хугацаандаа магистр, доктор хамгаалсан хүний тоогоор тухайн тэнхимд магистрт 100000, докторт 200,000 төгрөг олгодог урамшууллыг эрдэм шинжилгээний үйл ажиллагааны зардал болгож эд материалаар орлуулахгүй мөнгөн хэлбэрээр олгож байх

5.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Баримт нотолгоо:

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал

НАСС-ийн багш нарыг үе шаттай хөгжүүлж, багшлах ур чадварыг дээшлүүлэхэд заах арга зүй, асуудалд суурилсан сургалт, боловсрол судлалын сургалт, дээд боловсролын хөгжлийг дэмжих сургалт, оюутныг үнэлэх үнэлгээний арга хэлбэр, сорил, тохиолдол боловсруулах, гадаад хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зэрэг сургалтуудад хамруулсан байна. Сургалтын цөм хөтөлбөр боловсруулж гадаадын их, дээд сургуулиудын профессоруудыг урьж сургалт хийх, багш нарыг гадагш нь богино хугацааны сургалтанд явуулах зэрэг ажлуудыг сайн зохион байгуулсан байна. 2012-2017 онд давхардсан тоогоор багш нар 50 удаа гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан байна.

- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт

Багш бүр “Анагаах ухааны боловсрол судлал” сургалтанд хамрагдаж анагаах ухааны боловсрол судлалын хөгжлийн чиг хандлага, сургалтад шинээр нэвтэрч байгаа заах арга зүй, үнэлгээний арга хэлбэр, багшийн хөгжил зэрэг мэдээллүүдийг авдаг байна. 2 дахь магадлан итгэмжлэлийн хугацаанд 5 багш PBL-XI, 27 багш зочин профессорын, 28 багш эмнэлзүйн нарийн мэргэжлийн сургалтанд, 6 багш эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалтанд хамрагдсан байна. Сургалтаар олж авсан мэдлэгийг сургалтанд хэрэглэх ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй гэж өөрсдөө үзэж байна. Мөн мэргэжлийн мэдлэгээс гадна танин мэдэхүй, харилцааны ур чадвар, соёл, ёс суртахууны чиглэлийн сургалтуудыг түлхүү хийх нь чухал байгааг онцлон тэмдэглэжээ.

- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал

АШУҮИС-ийн гадаад харилцаа улам өргөжиж өнөөгийн байдлаар 24 орны 154 их, дээд сургууль, дэлхийн нэр хүнд бүхий байгууллага, нийгэмлэг, холбоодтой тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлж хамтарсан сургалт, судалгаа хийх, багш, оюутныг солилцох, мэдээлэл солилцох зэрэг ажлуудыг хийж байна. НАСС-ийн багш нар 2012-2017 онд гадаадын 9 оронд 40 удаа урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлж орчин үеийн шинэлэг техник технолгийг судалж сургалтанд ашиглаж байна. Ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл заадаг багш нарын хамтын ажиллагаа, хичээлийн уялдаа холбоог сайжруулж сурах бичиг хамтран бичих, НАС-ын хөтөлбөрт мэргэжлийн чиглэлийг түлхүү оруулах зорилгоор 2+4 хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлж эхлээд байна.

- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

2015-2017 оны хооронд 13 багш Солонгос, Япон, Герман, Куба, ОХУ-д богино хугацааны сургалтанд хамрагдсан бол 6 багш эдгээр орнуудад докторын зэрэг хамгаалжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын мэргэжил дээшлүүлэлтийг хамтран ажилладаг гадаадын их дээд сургуульдад хийн, өндөр мэргэжлийн зочин профессоруудаар орчин үеийн шинэлэг материал, техник технолги, харилцаа хандлагын талаар сургалт явуулдаг

Анхаарах асуудал:

- Сургалтаар эзэмшсэн зүйлсийг сургалтанд хэрэглэх тал дээр илүү анхаарах

5.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Баримт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо

АШУҮИС нь судалгааны их сургууль болох зорилт тавин МУЗГ, БСШУЯ-ны АШУҮИС-ийн хамтын хөрөнгө болох 5.4 тэрбум төгрөгөөр өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон анагаахын судалгааны ЦӨМ лабораторийг 2015 онд байгуулсан байна. 2015,16 онд багш Ж.Үржинлхам нар нь “Амны салстын дахилтат афт үрэвслийн эмнэлзүйн онцлог, эмчилгээнд Ахизунбер бэлдмэл хэрэглэсэн үр дүн, Ахизунбер бэлдмэлийн найрлага зэргээр Монгол улсын зохиогчийн эрхийн гэрчилгээ № 7349, патент № 4475-ыг авсан байна.

- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал

НАСС дээр 20112-2017 онд хэрэгжсэн 10 захиалгат төсөл, гэрээт ажилд багш нар амжилттай оролцож, хугацаанд нь гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.

- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал

НАСС-ийн судлаач багш нар төсөлт ажлыг багаар гүйцэтгэж үр дүнг олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, илтгэл хэлэлцүүлхээс гадна магистрант, докторантын ажлыг удирдаж хамгаалуулах ажил хэвшил болжээ.

- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

НАСС-ийн багш нар нь 2013-2017 онд үндэсний болон олон улсын нэр хүнд бүхий хэвлэлд 126 бүтээл хэвлүүлснээс 26 нь олон улсын сэтгүүл байсан байна. Олон улсад хэвлүүлсэн бүтээлүүдийн 6 нь IF өндөртэй сэтгүүлд хэвлэгджээ. Мөн 1 сэдэвт бүтээл 8, ном сурах бичиг, гарын авлага, удирдамж 17 бичиж, хэвлүүлсэн ба НАСС-ийн багш нарын олон улсад хэвлүүлсэн бүтээлүүдээс нийт 265 удаа эшлэл авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Судалгааны ажлын чанар үр дүн сайн учир IF- өндөртэй сэтгүүлд бүтээлээ хэвлүүлдэг.

5.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Баримт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан

АШУҮИС-ийн захирлын 2016 оны 11 сарын 9 –ний өдрийн А/118 тоот тушаалын 1-р хавсралтаар “ Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам” –ыг шинэчлэн баталж багш өөрийн үнэлгээний тайланг бичиж СБЗГ-ын харьяа Багшийн хөгжлийн төвөөр үнэлүүлдэг байна. Дадлагажигч багш жил бүр өөрийн үнэлгээний тайланг нотлох баримтын хамт багшийн хөгжлийн төвөөр үнэлүүлж, энэ нь хөдөлмөрийн гэрээг сунгах, цуцлах үндэслэл болдог. Багш, ахлах багш, дэд профессорын орон тоон дээр ажиллаж байгаа багш нар 3 жил тутамд, 15-аас дээш ажилласан багш нар 5 жил тутамд өөрийн үнэлгээний тайланг нотлох баримтын

хамт багшийн хөгжлийн төвөөр үнэлүүлсэн үнэлгээ нь албан тушаалын зэрэглэл ахих, буурах үндэслэл болдог байна. Тэнхимийн эрхлэгчийн үйл ажиллагааг 2 жил тутамд захирлын тушаалаар баталсан удирдамжийн дагуу шалгадаг байна. Дадлагажигч багшийн босго оноо 70%, багш 80%, ахлах багш, дэд профессор 90%, тэнхимийн эрхлэгч 80% байна. Профессорын ажлыг өөрийн үнэлгээний тайлангаар үнэлдэг журамтай, өөрийн үнэлгээний тайланг жилд 2 удаа зохион байгуулж хамрагдах багшийн нэрсийг захирлын тушаалаар баталгаажуулдаг байна. Сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжил, нийгмийн үйл ажиллагааны чиглэлээр албан тушаал тус бүрт өвөрмөц ажлын бүтээлийг тоо, чанарын хувьд илтгэх оноот шалгууруудаар хөндлөнгийн үнэлгээ хийнэ. Багшийн үүрэгт ажлыг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн 3 чиглэлээр 100 оноогоор үнэлнэ. Багшийн сургалтын үйл ажиллагааг үнэлэхдээ тэнхимийн үйл ажиллагаатай уялдуулан үнэлгээ сайн байвал багшид оноо нэмэх, хангалтгүй бол багшаас үнэлгээг хасдаг журам баримталдаг байна. Шүдний их эмч бэлтгэх НАС-ын хөтөлбөр хэрэгжүүлэгч бүх багш нар хуваарийн дагуу шалгагдсанаас бүгд хангалттай үнэлгээ авсан байна. 2015 онд 3 багш 70-95.9% үнэлүүлсэн бол 2016-18 онд 17 багш 82.2-98.5% -тай үнэлэгдсэн байна.

- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/

Сургалтанд ашиглаж байгаа UNIMIS систем нь улирал бүр багшийн үнэлгээний бодит байдал, оюутны хичээлийн ирц, сургалтын чанар, сургалтын нэгдсэн дүнг хянаж үүгээр зөвхөн оюутныг хянаад зогсохгүй багшийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх нэг боломж болдог байна.

- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа

НАСС нь орчин үеийн анагаах ухааны боловсролын онцлогийг даган асуудалд суурилсан оюутан төвтэй сургалтын хэлбэрт шилжсэн нь оюутныг бие даан мэдлэг, чадвар, хандлага дээшлүүлэхэд чиглэсэн сургалт явуулахын чухлыг харуулж байна.

- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал

НАСС-ын сургалтын алба нь жил бүр төгсөгчдөөс сургалтын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг хичээлийн агуулга, багтаамж, ачаалал, ном сурах бичгийн хангамж, сургалтын орчин, дадлагын хичээлд хэрэглэгдэж байгаа материал тоног төхөөрөмжийн талаар авч цаашдын ажилдаа анхааран сайжруулах арга хэмжээ авдаг байна. 2017-2018 онд авсан судалгаагаар 88.8% нь хичээлүүдийн агуулга багтаамж шаардлага хангасан, 89,7% лекцийн хичээл үр өгөөжтэй, 90% нь дадлага, семинар хангалттай, 43.9% хичээлийн давхардал бага гэсэн байна. 71% нь сургалтын орчин боломжийн, 72.7% нь сургалтанд хэрэглэж байгаа материал тоног төхөөрөмж шаардлага хангасан гэж хариулжээ. Багш нар аттестатчилалд орсны дараа гарсан алдаа дутагдлыг тэнхимийн хурлаар хэлэлцэж цаашид авах

арга хэмжээний талаар ярилцан төлөвлөгөө гарган ажиллахаас гадна тэнхимийн эрхлэгч 3 сар тутамд багшийг үйл ажиллагааг батлагдсан хуваарийн дагуу хэлцэж, тайланг бүрэлдэхүүн сургуулийн захиралд мэдээлдэг байна. Тэнхим тус бүр ажлын тайлангаа сургуулийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлтийг АШУИС-ийн Менежерийн үр дүнгийн тайланг танилцуулах захирлын зөвлөлийн өргөтгөсөн хуралд танилцуулдаг байна.

- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх

НАСС-ийн багш нар багш, оюутан, удирдлагаар үнэлүүлсэн үнэлгээндээ дүгнэлт хийж дадлагажигч багш улиралд 1 удаа нээлттэй хичээл хийж тэнхимийн эрхлэгч, багш нараар үнэлүүлдэг бол ахмад багш нар мөн нээлттэй хичээл хийж залуу багш нарыг дадлагажуулдаг байна. 2017-2018 онд авсан судалгаагаар судалгаанд оролцогчдын 95.3% нь багш нарын заах арга зүй, сургалтын түвшинг маш сайн, сайн гэж үнэлсэн байна.

- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Багш ажлын тайланг жил бүр гаргаж, 3 жил тутамд аттестатчлалд ордог учир багш бүр багшийн хавтсыг багшийн хөгжлийн төвөөс гаргасан журмын дагуу бүрдүүлдэг нь баримт материалыг эмх цэгцтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэж бүх багш нарын материал эмх цэгцтэй болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Баримт нотолгоо:

Сургалтын агуулга сургалтын хугацаа 5 жил байснаа 6 жил болсонтой холбоотой ерөнхий суурь, мэргэшүүлэх хичээл нэмэгдэж, мэргэжлийн суурь хичээл хасагдсан байна. Энэ талаар харьцуулан үзсэн байна.

Хүснэгт 3.Хөтөлбөрт тусгагдсан хичээлийн харьцаа

Хичээлийн хэлбэр	2010 оны төлөвлөгөө		2016 оны төлөвлөгөө	
	Багц цаг	Эзлэх хувь	Багц цаг	Эзлэх хувь
Ерөнхий суурь	44	24.4%	58	28.6%
Мэргэжлийн суурь	62	34.4%	46	22.6%
Мэргэшүүлэх	74	41.2%	99	48.8%
Нийт	180		201	

Суралцагчдын суралцах хугацаандаа гүйцэтгэх эмнэл зүйн үйлдлийн жагсаалтыг сонссон, харсан, хийсэн, чаддаг болсон 4 түвшинд ялган тусгасан. Уг гардан үйлдлийн жагсаалтанд Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэх чиглэлийн 17, Нүүр амны согог заслын 20, Нүүр амны мэс заслын 25, Нүүр амны эмчилгээний 23 үйлдлийг дээрх 4 түвшингээр ангилан оруулжээ. Мэргэжилтний цогц чадамж болон гардан үйлдлийн жагсаалтын дагуу суралцагчдад мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэхээр сургалтын хөтөлбөртөө тусган ажиллаж байна. Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан харьцуулалт хийсэн байна. Хүснэгт 4.

Хүснэгт 4. Хөтөлбөрт тусгагдсан онол, практикийн харьцаа

	2010 оны төлөвлөгөө			2016 оны төлөвлөгөө			Зөрөө	
	Цаг	Багц цаг	Харьцаа	Цаг	Багц цаг	Харьцаа	Цаг	Багц цаг
Цаг	4712	180		9648	201		4936	
Лекц	1056	66	1	1172	73	1	116	7
Семинар	440	13.5	0.42	487	15.2	0.42	47	1.7
Дадлага	2672	83.5	2.53	2579	80.8	2.2	-93	-2.7
Бататгах	-		0	1022	32	0.87	1022	32
Бие даалт	544	17	0.52	4388	-	3.74	3844	-17

Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг Улаанбаатар болон хөдөө орон нутагт төрийн өмчийн болон төрийн өмчийн бус эмнэлэгүүдтэй хамтран хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр байгууллагууд дээр сувилагчийн, туслах эмчийн, нүүр ам судлалын их эмчийн дадлагаа суралцагчид хийх явцдаа төгсөөд ажиллах боломж нээгддэг байна. АШУҮИС-ийн хэмжээнд цахим хичээлүүдийг контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан үйл ажиллагаа өрнөж байгаа бөгөөд энэ хүрээнд нүүр ам судлалын мэргэжлийн цахим ном 153, мэргэжлийн сэтгүүл 173 хэрэглэгдэж байна. Мөн “Эмнэл зүйн харилцааны ур чадвар” цахим хичээл болж сургуулийн цахим баазад байршсан байна.

Тус хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангах зорилгоор дамжаа, хичээлийн төрлийн уялдаа холбоог боловсруулан гаргаж, түүнийг илэрхийлсэн хүснэгт тайландаа тусгасан байна. Тус хөтөлбөрийн суралцагч хичээл, багшийг сонгон суралцах боломж хязгаарлагдмал байдаг талаар оюутан суралцагчид уулзалтын үеэр дурдаж байв.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- НАСС-ийн Нүүр ам судлалын бакалаврын хөтөлбөр нь сургуулийнхаа дэргэд нүүр ам судлалын эмнэлэгтэй бөгөөд суралцагчид дадлага хийх, бодит эмчилгээний үйл явцыг боловтой үедээ ажиглах, дагалдан суралцах таатай сургалтын орчин нөхцөлийн давуу бөгөөд онцлог талтай байна.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Баримт нотолгоо:

Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар-Тус сургалтын хөтөлбөрийн зорилгод нийцсэн цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй сургалтын арга зүйг түлхүү ашигладаг. Үүндээ тулгуурлан сургалтын болон хичээлийн бүх хөтөлбөрийг боловсруулан мөрдөж байна.

Чадамжинд суурилсан арга: Нээлттэй бие даан суралцах бололцоог хангаснаар оюутан хичээлийн агуулгын 80%- ийг практик амьдралд чиглэсэн үйл ажиллагааг гүйцэтгэх замаар чадвар мэдлэг дадлыг олж эзэмших ба хөдөлмөрч бүтээлч болж, ажил хөдөлмөрт хандах хандлагыг өөртөө төлөвшүүлэн суралцах юм.

Асуудалд суурилсан арга: Оюутнууд асуудлыг багаар хамтарч ажиллан шийдвэрлэдэг оюутан төвтэй сургалтын стратеги юм. Асуудал дээр ажилласнаар оюутнууд бие даан суралцах замаар мэдлэг эзэмших, мөн бүлгийн ажил, бүлгийн төсөл удирдаж сурах төдийгүй харилцааны чадвар нь сайжирч асуудал шийдвэрлэх дадал эзэмшинэ.

Харилцаанд суурилсан арга: Оюутныг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэн бусдыг сонсож сурах, бичгийн чадвартай болгох, хэл ярианы илтгэх, ярих тайлбарлах, өөрийгөө хүнд ойлгуулах, ойлголцох чадварыг нэмэгдүүлэхэд чиглэж, хичээлийг илүү амьдлаг идэвхтэй, үр өгөөжтэй хэлбэрээр явуулдаг арга бөгөөд эмнэлзүйн орчинд эмч хүний харилцааны ур чадварын суурь болдог.

Даалгаварт суурилсан арга: Оюутнууд тодорхой дасгал даалгаврыг дүрд тоглох арга ашиглан бодит байдлаар үйлдэж гүйцэтгэснээр оюутны мэдлэг чадвар сайжрахын зэрэгцээ харилцааны чадвар багаар ажиллах чадвар, асуудалд бүтээлчээр хандах чадвар зэрэг цогц чадамж төлөвшинэ.

Баг, бүлгийн арга: Бүлэг багийн ажил нь харилцан идэвхтэй сургалтын арга бөгөөд сургалтын хөтөлбөрт зайлшгүй багтах ёстой. Бүлгээр ажиллах үед хувь хүний оролцоо идэвхжиж, оюутнууд бие биеэсээ суралцах мэдээлэл авах бие биендээ зааж сургах зэргээр мэдлэг бүтээх улмаар өөрийгөө бусадтай харьцуулан үнэлэх үнэлгээ хийх боломжийг олгодог.

PPP-ийн арга (Presentation, Practice, Production). Үзүүлэн сургалт нь хүний харах мэдрэхүйд тусдаг тул оюутны олж авах мэдлэгийн 40%-ийг харах мэдрэхүйгээр олж авдаг сургалтын хамгийн өгөөж үр нөлөөтэй аргачлал юм.

Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал

Дадлага, семинарын хичээлийг SOP- ийн дагуу ижил удирдлагаар удирдан явуулдаг. Профессор, дэлгэц, үзүүлэн, сурах бичиг, гарын авлага бусад материалаар бүрэн хангагдсан. Физикийн хичээл шалгалтын сорилын баазтай (700) Articulate Quiz marker 6.0 программыг ашиглан явуулдаг.

Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа

Их сургуулийн удирдлага мэдээллийн системийг (UNIMIS) ашиглаж суралцагчийн бүртгэл, дүнгийн нэгдсэн системтэй болсон нь суралцагчдын дүнгийн найдвартай байдал сайжрах боломжтой болсон. Шүдний их эмч бэлтгэх НАС-ын сургалтын хөтөлбөрөөр суралцагчдад цахим шуудангийн хаяг нээж өгсөн нь мэдээлэл солилцох, даалгавар, бие даалт хураалгах зэргээр өргөн ашиглаж байна.

Шүдний их эмч бэлтгэх НАС-ын хөтөлбөрт тусгагдсан сонгон судлах хичээлийн лекцүүд цахим хэлбэрт шилжсэн нь нэг талаас сургалт явуулж байгаа өрөө, тасалгааны танхимын ачааллыг бууруулж, нөгөө талаас суралцагчийн танхимын сургалтын ачааллыг багасгах боломж олгосон. Бүртгэл мэдээллийн систем (UNIFACE, UNIMIS) нэвтрүүлснээр суралагчид сурлагын дүнтэй танилах боломжтой болсон. Энэхүү системийн аюулгүй ажиллагааг хангах, хүчин чадлыг сайжруулах асуудал байгаа аж. /150/

Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал: Сургалтын арга зүйдээ дүн шинжилгээ хийж даалгаварт суурилсан арга, асуудалд суурилсан арга, үзүүлэн сургалт, харилцаанд суурилсан арга, чадамжинд суурилсан арга зэргээр тодотгон дүгнэлт хийж хөгжүүлж байгаа бөгөөд энэ талаар багш нартаа сургалт семинар зохион байгуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Асуудалд суурилсан арга: Оюутнууд асуудлыг багаар хамтарч ажиллан шийдвэрлэдэг оюутан төвтэй сургалтын стратеги юм. Асуудал дээр ажилласнаар оюутнууд бие даан суралцах замаар мэдлэг эзэмших, мөн бүлгийн ажил, бүлгийн төсөл удирдаж сурах төдийгүй харилцааны чадвар нь сайжирч асуудал шийдвэрлэх дадал эзэмшдэг.

Зөвлөмж:

- НАС-ын хөтөлбөрт жил бүр шинэчлэл хийхдээ агуулгыг нэгдсэн байдлаар гаргах шаардлагатай.
- Сургалтын хөтөлбөрийн хүрээнд арга зүйн судалгаа хийж дүгнэн хөгжил дэвшлийн зураглал гаргадаг байх.

6.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ

“АШУҮИС-ийн суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх журам”-аар зохицуулагддаг. Суралцагчдын мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга аргачлалтай, түүнийгээ сургуулийн хэмжээнд хэрэглэдэг.

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга хэлбэр нь суралагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг. Ийм байхыг тулд АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газраас бүх салбар сургууль, багш нараа сургуулийн дотоод эрх зүй, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахын зэрэгцээ үнэлгээний асуудлаар гарын авлага хэвлэж түгээх, арга зүйн сургалт зохион байгуулах зэрэг ажил зохион байгуулдаг байна.

Суралцагчийн үнэлгээ нь ил тод найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал: <http://student-web.xcloud.mn/login>сайтаар дамжуулан үнэлгээний мэдээллээ авдаг. Гэхдээ оюутнуудтай хийсэн уулзалтын үеэр зарим хичээлийн дүнгээ мэдэхгүй явсаар улирал дуусахад системд дүн орсон байдаг, дүнгийн талаар тодруулах боломжгүй байдал үүсдэг хүндрэл гардаг гэсэн асуудал гарсан.

2013-2014 оны хичээлийн жилд төгсөгчдийн онолын шалгалтын дундаж дүн 79 хувь, 2014-2015 оны хичээлийн жилд төгсөгчдийн дундаж дүн 74 хувь, 2015-2016 оны хичээлийн жилийн төгсөгчдийн дундаж дүн 90 хувь, 2016-2017 оны хичээлийн жилийн төгсөгчдийн дундаж дүн 77 хувь 2017-2018 оны хичээлийн жилийн төгсөгчдийн дундаж дүн 89 хувьтай байсан ба дээрх дүнгээс харахад сүүлийн 5 жилд төгсөгч оюутны онолын шалгалтын дүн өссөн үзүүлэлтэй байна.

Суралцагчийн гаргаж буй амжилтууд: 2013-2014 оны хичээлийн жилд төгсөгчдийн дадлага шалгалтын дундаж дүн 81,8 хувь , 2014-2015 оны хичээлийн жилд төгсөгчдийн дундаж дүн 76.9 хувь, 2015-2016 оны хичээлийн жилийн төгсөгчдийн дундаж дүн 89.7 хувь, 2016-2017 оны хичээлийн жилийн төгсөгчдийн дундаж дүн 87.9 хувь 2017-2018 оны хичээлийн жилийн төгсөгчдийн дундаж дүн 91.9 хувьтай байсан ба төгсөгчдийн үзүүлсэн дадлага шалгалтын үр дүн нь сүүлийн 5 жилд өссөн үзүүлэлтэй байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдын эзэмшсэн мэдлэг чадварын найдвартай, бодитой үнэлэх арга аргачлалыг боловсруулах талаар нэгдсэн арга зүйгээр ханган чиглүүлэх ажлыг АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газраас бодлого төлөвлөгөөтэй хийснээр “Нүүр ам судлал” бакалаврын хөтөлбөрийн хүрээнд судалж буй хичээлүүдийн үнэлгээний арга зүйн боловсруулалт найдвартай бодитой байхад илүү чиглэсэн байна.

Зөвлөмж:

- Суралагчдын дүнг тухай бүр нь мэдэгдэж байхыг бүх багш нарт мэдээллэж үүнийг мөрдөх, түүнд хяналт тавих.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Баримт нотолгоо:

- *Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэжүүлдэг байдал*

2011-2018 онд 718 шүдний эмч төгссөнөөс 379 буюу 52.8% нь ажил эрхэлж, 21.4% нь гадаад, дотоодын их дээд сургуульд магистрантур, докторантур, резидендийн сургалтанд хамрагдаж, 12.3% нь огт ажил эрхлээгүй байна. Ажил эрхэлж буй төгсөгчдийн 83.9% нь мэргэжлээрээ, 6.3% нь төрийн албанд, 8.4% нь эрүүлийг хамгаалахаас бусад салбарт, 1.3% нь их дээд сургуулиудад багшилж байна.

- *Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа*

Сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдагсдын 52.8% ажил эрхэлж байгаагийн 44.3% нь мэргэжлийн чиглэлээр, 6.3% нь төрийн албанд мэргэжлээрээ, 1.3% нь их дээд сургуульд, 4.3% нь 3-р шатлалын эмнэлэгт, 12.5% нь 2-р шатлалын эмнэлэгт, 4.2% нь 1-р шатлалын эмнэлэгт, 65.3% нь хувийн эмнэлэгт ажиллаж байна. Нийт төгсөгчдийн 13.1% нь резидентийн, 0.6% нь докторын, 1.7% нь магистрын сургалтанд суралцаж байна. 88.9% нь энэ мэргэжлийг эзэмшсэндээ сэтгэл ханамж өндөр байсан бол 11.1% нь сэтгэл ханамж дунд зэрэг байсан байна. Төгсөгчдөөс 23 асуумжаар судалгаа авсанаас 40.4% нь сургалтын хөтөлбөрийн агуулгад сэтгэл ханамжтай гэсэн бол 2.7% нь ханамжгүй гэжээ. 68.2% нь төгсөөд шууд ажиллахад мэдлэг, чадвар хангалттай, 29.1% нь сурах шаардлагатай байсан, 2.7% нь хангалтгүй байсан гэжээ. НАС-ын хөтөлбөрийн эмнэлзүйн дадлагын хичээлийн орчинд 48.6% ханамж өндөр, 38.9% ханамж дунд, 12.5% ханамж бага, 50.1% үндэсний сурах бичиг, гарын авлага хангалттай гэсэн байна. 58.5% олж авсан онолын мэдлэг, 79.2% дадлагын хичээлээр авсан чадвар хангалттай байсан гэжээ. 56.9% НАСС-ийн хөтөлбөр зах зээлийн шаардлагыг сайн хангасан гэсэн бол 43.1%

дунд гэж үзэж байна. НАС-ын чиглэлээр ажиллаж байгаа хувийн ба улсын төв эмнэлгүүдийн ажил олгогчдоос 32 асуултаар авсан судалгаанд 53.3% нь НАСС-ийн төгсөгчид ажлын байрны шаардлагад нийцдэг, мэргэжлийн мэдлэг хангалттай гэсэн бол мэргэжлийн чиглэлээс маш сайн мэдлэг олгодог НАЭ-/80%/, ХНАӨУС-/63.3%/ , НАМЗ /51.3%/ , бол НАСГЗ /26.7%/ мэдлэгийг дульхан олгодог, төгсөгчийн технологийн мэдлэг сайн /56.6%/ , гадаад хэлний мэдлэг сайн /26.6% / гэжээ. Мөн төгсөгчдийн эмнэлзүйн харилцааны чадварыг 40% нь сайн, 56.6% нь сэтгэн бодох, тоног төхөөрөмжтэй ажиллах чадвар сайн, 43.3% нь багаар ажиллах, 43.4% нь төлөвлөх, 50% нь ажлыг шаардлагын түвшинд гүйцэтгэх , 50% нь бие даан ажиллах, 40% нь шинийг санаачлах, 40% нь зохион байгуулах чадвар сайн гэж үнэлсэн байна. Ажил олгогчдын 60% нь харилцааны соёл сайн, 53.3% нь хувийн зохион байгуулалт, ёс суртахуун сайн гэжээ.

Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацааг судлахад 65.3% нь төгсөөд 3 хүртэл сарын дотор, 12.5% нь 4-6 сар, 2.8% нь 7-12 сар, 18% нь 1 жилээс дээш хугацаанд ажлын байраар хангагдсан байна. Төгсөгчдийн 66.8% нь багш нартайгаа холбоотой бажилладаг гэсэн бол судалгаанд оролцогчдын 61.2% нь НАСС-ийн удирдлагын зүгээс эргэх холбоо дунд гэж үнэлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Оюутны эмчийн ёс зүй харилцаа хандлагын төлөвшлийг сайжруулах
- Сургууль ба төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах

7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд

НАСС-ийг 2011-2017 төгсөгчдийн анагаах ухааны доктор 19, дэд профессор 7, профессор 3, Монгол улсын хүний гавьяр эмч 1 байна.

- *Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь*

Төгсөгчдийн 28% нь их дээд сургуулийн захирал, хувийн эмнэлгийн дарга, эрдэм шинжилгээний байгуулгын захирал, аймаг, сум, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга, менежер, эмнэлгийн тасаг, нэгжийн эрхлэгч зэрэг удирдах албан тушаал хашиж байна.

- *Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/*

Төгсөгчдийн 74.4% нь гадаад, дотоодод НАС-ын салбарт хүч хөдөлмөрөө зориулж байна. 32 төгсөгч мэргэжлийн чиглэлээр хувийн эмнэлэг, компани байгуулан ажиллаж, 5.8% нь Япон, Солонгос, Тайванд сурч байгаа, 1.3% нь их дээд сургуульд мэргэжлээрээ багшилж, төгсөгчдийн 74.4% нь НАС-ын салбарыг хөгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсан гэж үзэж байгаа боловч хувь нэмрээ оруулаагүй байгаа 25.6% -ийг салбараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талын ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Баримт нотолгоо:

Суралцаж буй гадаад оюутны тоо – БНСУ-ын 2 оюутан төгсөлтийн өмнөх сургалтад суралцаж төгссөн

- *Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт*

АШУҮИС-ийн дэргэд байгуулагдсан олон улсын Сайбар их сургууль нь НАС-ын чиглэлээр онлайн сургалтаар гадаад, дотоодын суралцахыг хүсэгчдэд сургалт хийх боломж олгосон

- *Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт*

Оюутан Ц. Баттулга олон улсын тэмцээнд оролцож Пауэрлифтингийн ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ МАСТЕР болсон

- *Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь*

Гадаадын докторантурыг 25, магистрантурыг 11, докторын дараах болон урт богино сургалтанд 16 төгсөгч суралцаж төгссөн байна. 2011-2017 онд төгссөн 718 төгсөгчийн 5.8% нь /46 төгсөгч/ гадаадад мэргэжлээрээ суралцаж 100% магистрын зэрэг, 50% нь докторын зэрэг хамгаалсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Баримт нотолгоо:

- *Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал*

Хөтөлбөрийн зорилго, зорилтын биелэлтийн талаар жил бүр багш оюутны хамтарсан хурлаар хэлэлцэж нээлттэй санал асуулга явуулдаг. Мэргэжил сурталчлах өдөрлөгийг улирал бүр ерөнхий боловсролын сургуулиуд, байгууллага, ард иргэдийн дунд зохиодог

Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа – хөтөлбөрийн үйл ажиллагааг цахим хуудсаар нийтэд түгээн сурталчилж, улирал бүр мэдээллийг шинэчлэдэг. Сургуулийн үйл ажиллагаа, сургалттай холбоотой мэдээллийг <http://mnums.edu.mn/>, НАС-ын сургууль <http://dentistry.mnums.edu.mn/> вейб хуудас 2017 онд ашиглаж эхэлсэн, багш оюутанд зориулсан <http://www.teacher-web.xcloud.mn/login> вейб хуудсыг шинэчлэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажууллыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн-АШУҮИС нь 2018 оны 9-р сараас Чанарын баталгаажуулалтын албатай болсон.

Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ-Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөтэй. Тусгай гарын авлага бэлтгэн салбар сургуулиуддаа ажлын хэрэгцээнд түгээсэн. Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу ажилладаг. Сургалтын хөтөлбөрийн шинжилгээ үнэлгээ давтамжтай хийгдэж байдаг.

Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо-багш, суралцагчид, төгсөгчид, ажил олгогчдоос асуулга судалгаа, мөн сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Төгсөгчдийн 65,3% төгсөөд 0-3 сарын дотор, 12,5% 4-6 сарын дотор, 2,8% 7-12 сарын дотор, 18% 1 жилээс дээш хугацаанд ажилтай болсон байна.

Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал - АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургууль удирдлагын өөрийн үнэлгээг сайжруулан, чанарыг эрхэмлэн хэрэглэгчдийн хэрэгээг хангасан үндэсний хэмжээний сургууль болоход Чанарын удирдлагын тогтолоо ISO9001-2015 олон улсын стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. ISO9001-2015 олон улсын стандартыг нэвтрүүлснээр сургуулийн хэрэглэгч харилагчлын сэтгэл ханамж дээшилж, багш ажиллагчдын ур чадвар зогсолтгүй хөгжин дэвших болно гэж үзжээ.

Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал: Мэргэжлийн салбар дахь нөлөөллийн буюу үр нөлөөний үнэлгээ хийсэн байна.

Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал: 1961 оноос хойш 11 удаа өөрчлөлт орсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургууль удирдлагын өөрийн үнэлгээг сайжруулан, чанарыг эрхэмлэн хэрэглэгчдийн хэрэгээг хангасан үндэсний хэмжээний сургууль болоход Чанарын удирдлагын тогтолоо ISO9001-2015 олон улсын стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. ISO9001-2015 олон улсын стандартыг нэвтрүүлснээр сургуулийн хэрэглэгч харилагчлын сэтгэл ханамж дээшилж, багш ажиллагчдын ур чадвар зогсолтгүй хөгжин дэвших болно гэж үзжээ.

Анхаарах асуудал:

- Сургалтын Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг тогтмол хийж байх.
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байх, түүнийгээ нэгтгэн илэрхийлэх.
- Сургалтын хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байх, түүнийгээ илэрхийлэн тайлбарлах.

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ:

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаа гүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт /3/	Бүрэн хангасан			
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл /3/	Бүрэн хангасан (БХ, БХ, ХХ)			
3	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт /6/	Бүрэн хангасан			
4	Суралагчдад чиглэсэн үйл ажиллагаа /5/	Бүрэн хангасан			
5	Багшийн үйл ажиллагаа /4/	Бүрэн Хангасан (ХХ, БХ, БХ,БХ)			
6	Сургалтын үйл ажиллагаа /3/	Бүрэн хангасан			
7	Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө /4/	Бүрэн хангасан			
8	Чанарын үнэлгээ баталгаажилт /1/	Бүрэн хангасан			

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн “Нүүр ам судлал” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Ж.Даваа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Оюунбат/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Л.Баярцэцэг/

V. Оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

2019.03.20-21

№	Овог нэрс	Тэнхим, албан тушаал	Утас	Гарын үсэг
1.	А.Мөнхдөл	НАМЗ тэнхимийн эрхлэгч	88108471	
2.	Х.Намуун	НАМЗ дадлагажигч багш	99336398	
3.	Г.Батболд	НАМЗ багш	96110330	
4.	Б.Сапаар	НАСЗ тэнхимийн эрхлэгч	88103915	
5.	С.Дэжидноров	НАСЗ дадлагажигч багш	96962724	
6.	Ж.Үржинлхам	НАЭ тэнхимийн эрхлэгч	99086968	
7.	М.Батсуурь	НАЭ дадлагажигч багш	88019596	
8.	Б.Од	НАГЗ тэнхимийн эрхлэгч	94011510	
9.	С.Болормаа	НАГЗ дадлагажигч багш	99886360	
10.	Б.Оюунцэцэг	ХНАСУСТ тэнхимийн эрхлэгч	91916289	
11.	А.Сувданчимэг	ХНАСУСТ дадлагажигч багш	99010856	

II. Оюутны нэр

2019.03.20-21

№	Оюутны нэрс	НАС дамжаа	Сонгосон байдал	Утас	Гарын үсэг
1.	Түмэндэмбэрэл	3	Сайн дурын байгууллагын гишүүн	99484981	
2.	Шүрэнцэцэг	3	Дотуур байранд амьдардаг	99825520	
3.	Өнөзаяа	3	Нийгмийн идэвхи		
4.	Халиун	3	Сурлага		
5.	Хулан	3	Сайн дурын байгууллагын гишүүн		
7.	Отгонтүлхүүр	4	Хөдөө орон нутаг		
8.	Лхагвадорж	4	Дотуур байранд амьдардаг	99662920	
9.	Намуундарь	4	Сурлага	99604669	
10.	Отгонням	4	Дотуур байранд амьдардаг	89280299	
11.	Чөдөрбат	4	НАСОН-ы тэргүүн	99122310	
12.	Тэмүүжин	4	Нийгмийн идэвхи	80066636	
13.	Баярбилэг	4	Хөдөө орон нутаг	88719162	
14.	Пүрэв-Очир	4	Орон нутгийн оюутан	99655131	
15.	Хүслэн	5	НАСОН-ы дэд тэргүүн	99667835	
16.	Оюундарь	5	Orthodontics тэргүүн	88143283	
17.	Шүрэнцэцэг	5	Сурлага	86091069	
18.	Цэнгэлсүрэн	5	Сайн дурын байгууллагын гишүүн	80606660	

III. Ажил олгогч

2019.03.20-21

№	Нэр	Байгууллага албан тушаал	Утас	Гарын үсэг
1.	Баярчимэг	Глобал	94008808	
2.	Дөлгөөн	Сүүн шүдхэн	99123565	
3.	Билэгээ	Дижитал дентал	99100925	
4.	Амгалан	Эпуда	99082808	
5.	Пунсалдулам	Танан цагаан	99990200	
6.	Майцэцэг	Mayflower	88116344	
7.	Лхагваа	Их зайсан	99195025	
8.	Эрдэнээ	Фиссурит	99244059	
9.	Чулуунцэцэг	Очирдент	88103915	
10.	Хэнтий	Нийслэлийн Шүд Эрүү Нүүрний Төв	99193524	
11.	Янжиндолгор	Туждент	99193863	
12.	Тунгалаг	Сайхан шүд	96228424	
13.	Оюунтунгалаг	Crystal Dental	98885099	
14.	Болормаа	Болордент		
15.	Пүрэвжав	Эстедент	98881608	

IV. Төгсөгчид

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага албан тушаал	Утас	Гарын үсэг
1.	Юмчинсүрэн	2016	Шинэ дэлбээ эмнэлэг	99163098	
2.	Энхцэцэг	2018	Танан цагаан эмнэлэг	99060193	
3.	Амаржаргал	2017	Редидент эмнэлэг	99911148	
4.	Мөнхзул	2017	Солонго эмнэлэг	99241550	
5.	Мөнхгэрэл	2016	Энх Смайл эмнэлэг	99144390	
6.	Ундрам	2016	Цэмгар эмнэлэг	88013108	
7.	Хангал	2017	Smail dent эмнэлэг	95919842	
8.	Энхцэцэг	2016	Сувд дент эмнэлэг	89184377	
9.	Даваадорж	2016	Magics smile эмнэлэг	89675591	
10.	Дэлгэрцэцэг	2015	Индранил эмнэлэг	99017783	
11.	Э.Очирсаран	2018	Хувиараа	95705720	
12.	Н.Өлзийтогтох	2013	Хувиараа	99088167	
13.	Г.Халиун	2016	Индранил эмнэлэг	99973330	
14.	Н.Энхмаа	2016	Өвөрхангай аймаг	89999515	
15.	А.Номин	2017	Хувиараа	99130176	
16.	А.Бөртэжин	2017	Өвөрхангай аймаг Зүүнбаянулаан сум эмч	99323072	
17.	Б.Цэнд-Аюуш	2017	Family dent эмнэлэг	88773916	

